



МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ,
СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ
АРГА ЗҮЙН ТӨВ



БАТЛАВ
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН
ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙН ТӨВИЙН
ДАРГА *Ц.Батдорж* Ц.БАТДОРЖ



МОНГОЛ УР ЧАДВАР 2021
САНТЕХНИКЧ МЭРГЭЖЛИЙН
УР ЧАДВАРЫН ТҮВШИН ТОГТООХ ҮНЭЛГЭЭНИЙ
II ШАТНЫ УДИРДАМЖ, ДААЛГАВАР

Зохион байгуулагч байгууллага:

Монгол улсын Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв
Мэргэжлийн боловсрол түншлэл ТББ
Монголын Барилгачдын Нэгдсэн Холбоо

Улаанбаатар хот

2021 он

Нэг. Ур чадварын түвшин тогтоох үнэлгээний зорилго

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын нэр хүндийг дээшлүүлэх, сантехникч мэргэжлийн суралцагчдын ур чадварыг ахиулах, мэргэшүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, урамшуулах, дэмжих, тэдний ур чадварын түвшинг олон улсын жишигт хүргэх замаар хөгжлийн чиг хандлага, мэргэжлийн чадвар чадамжийг тодорхойлон, 2022 онд БНХАУ-н Шанхай хотод болох “Дэлхийн ур чадварын 46-р тэмцээн”- д оролцогчийг сонгон шалгаруулах зорилготой.

Хоёр. Зохион байгуулах газар, хугацаа

Ур чадварын түвшин тогтоох үнэлгээ 2021 оны 12 дугаар сарын 16-20- ний өдөр Барилгын Политехник Коллежийн сантехникийн дадлагын газарт зохион байгуулагдана.

Гурав. Хамрах хүрээ

2022 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 22 нас хүрээгүй Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч байна.

Дөрөв. Үнэлгээний багийн бүрэлдэхүүн

“Монгол ур чадвар” үнэлгээний журамд заасан шалгуурыг хангасан, эрх бүхий үнэлгээний ажилтан , баталгаажуулагч байна.

Тав. Үнэлгээний нийтлэг шаардлага

1. Оролцогч нь Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч бөгөөд тухайн сургууль албан ёсоор ур чадварын түвшин тогтоох үнэлгээнд оролцуулахаар нэр дэвшүүлсэн байна.
2. Үнэлгээг дэлхийн ур чадварын тэмцээний стандарт болон үнэлгээний системийн зохион байгуулна.
3. Оролцогчид нь үнэлгээний удирдамж, техникийн баримт бичгийг мөрдөж ажиллана.
4. Зохион байгуулагчийн зүгээс удирдамжид тусгасан зарим багаж хэрэгслийг оролцогчид авчирна.
5. Оролцогчид ХАБЭА болон аюулгүй ажиллагааг бүрэн ханган ажиллана.
6. Оролцогчид оролцооны төлбөрийг төлсний дараа бүртгэлийг баталгаажуулна.
7. Зохион байгуулагчийн зүгээс гаргасан Ковидын үеийн халдвар, хамгааллын дэглэмийг чанд баримтлан оролцоно.
8. Сонирхогч болон үзэгчид тэмцээний байранд нэвтрэхгүй зөвхөн зайнаас ажиглах боломжийг олгоно.

Зургаа. Зохион байгуулалт

1. Мэргэжлийн ур чадварын түвшин тогтоох үнэлгээг ерөнхий зохион байгуулагч Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвийн даргын баталсан удирдамж, Монгол Ур чадвар тэмцээн зохион байгуулах журмын хүрээнд зохион байгуулна.

2. Ур чадварын түвшин тогтоох үнэлгээнд оролцогч COVID-19 вакцины 3-р тунг хийлгэсэн байх. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 12 дугаар сарын 20-ны хооронд II-р шатны үнэлгээ болно.

Лавлах утас: 11-314516, 318685, 976-99061944

Оролцогчид бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлнэ.

- А. Сургуулийн тодорхойлолт
- Б. Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ /эх хувиар/
- В. 3*4 хэмжээтэй 1% цээж зураг
- Г. Хураамж төлсөн баримт

3. Сургууль тус бүр оролцогчийн хураамжийг бүртгүүлэхээс өмнө төлсөн байх ба нэг оролцогчийн бүртгэлийн хураамж 500,000 төгрөгийг Монголын Барилгачдын Нэгдсэн Холбооны Худалдаа Хөгжлийн Банкн дахь 453035914 тоот дансанд /Дансны нэр: Монголын барилгачдын нэгдсэн холбоо, Регистр:1012509 тушаах ба гүйлгээний утган дээр сургууль, овог нэр байна.

4. Техникийн зөвлөгөөнийг үнэлгээний өмнө буюу 12 сарын 15-ний 10.00 цагт Барилгын Политехник Коллежийн хичээлийн байранд техникийн зөвлөгөөнийг зохион байгуулна. Үнэлгээнд оролцож буй сургуулиуд болон мэргэжлийн багш, үнэлгээний ажилтнууд, хөндлөнгийн баталгаажуулагч нар **Техникийн зөвлөгөөнд** заавал оролцох шаардлагатай.

5. Урьдчилан нээлттэй зарласан үнэлгээний даалгаварт хийсэн 30%-ын өөрчлөлтийг техникийн зөвлөгөөн дээр танилцуулна.

6. Зохион байгуулагч тал үнэлгээ хийх ажлын байр, хэрэглэгдэх материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бэлтгэнэ.

7. Ур чадварын түвшин тогтоох үнэлгээний оролцогчдод эрхийн мандат олгоно.

8. Ур чадварын түвшин тогтоох үнэлгээний үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, халдвар хамгааллын дэглэмийг зохион байгуулагч тал хариуцна.

9. Үнэлгээний даалгавар гүйцэтгэл нийт 8 цаг байна. Үүнд цай хоолны завсарлагын цаг ороогүй болно.

10. Хоёрдугаар шатнаас 1 шилдэг оролцогчид шалгарч ДУЧТ-д оролцох эрх авна.

Долоо . Ажлын даалгавар

Удирдамжийн дагуу урьдчилан бэлдсэн тасалгаанд халаалтын системийн угсралт, цэвэр усны шугамын угсралт, бохир усны шугамын угсралтын ажилбарыг хийж гүйцэтгэнэ.

Халаалтын ажлыг гүйцэтгэхдээ радиаторыг хананд бэхлээд салбар шугам, босоо шугамыг зургийн дагуу холбоно.

Цэвэр усны шугамын ажилбарыг хийж гүйцэтгэхдээ хананд хэмжээ тавьж холбох хэрэгслийг бэхэлж, салбар шугам ба босоо шугамыг зургийн дагуу угсарч холбоно.

Бохир усны шугам угсрах ажилбарыг гүйцэтгэхдээ шугамын налууг тааруулж бэхэлгээ хомутыг норм дүрмийн дагуу угсарч гүйцэтгэнэ.

Тэмцээний даалгаврыг урьдчилан зарлах бөгөөд техникийн зөвлөгөөний дараа талбай дээр байгаа материалд тааруулан 30%-ийн өөрчлөлтийг мэргэжлийн багш нарын төлөөлөл, шүүгч нар хамтран даалгаврыг гаргана.

Найм. Үнэлгээнд хэрэглэх гар багаж, хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал









Зохион байгуулагчийн зүгээс суурин тоног төхөөрөмжийг 3 оролцогчийн дунд 1 ширхгийг тус тус бэлтгэсэн байна.








1. Тэмцээнд оролцогчид шаардлагатай гар багаж, хэрэгсэл, гар цахилгаан багажуудыг өөрсдөө бэлтгэн авчирна.





Үүнд:

Оролцогчийн шаардлагатай багаж хэрэгслийн жагсаалт

№	Шаардлагтай багаж хэрэгсэл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Багажны зураг
1	Францус	ком	1	
2	Хэрээ хошуу	ш	2	
3	Шруп мастер	ш	1	
4	Даралт нэмэгч пресс багаж	ш	1	

5	Төмрийн хөрөө	ш	1	
6	Төмрийн хуурай	ком	1	
7	PVC хайч	ш	1	
8	PVC хоолой таслагч	ш	1	
9	Өнцөг хэмжигч	ш	2	
10	Ам цэвэрлэгч PVC	ш	1	
11	Метр	ш	2	
12	Тэгш ус 200-1000мм	ш	Тус бүр 1	

13	PVC матагч	хоолой	КОМ	1	 <p>180° Pipe Bending Machine 15mm</p> <p>By Martin Smith www.courtesytooluk.com</p>												
14	Гар клуп		КОМ	1													
15	Ган матагч	хоолой	Ш	1	 <table border="1" data-bbox="932 999 1267 1032"> <thead> <tr> <th>Model</th> <th>Max. pipe size</th> <th>Stroke</th> <th>Clamp diameter</th> <th>Wall thickness</th> <th>Weight</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>158C-25</td> <td>60"</td> <td>1200MM</td> <td>1143-1219MM</td> <td>1.5-24MM</td> <td>20KG</td> </tr> </tbody> </table>	Model	Max. pipe size	Stroke	Clamp diameter	Wall thickness	Weight	158C-25	60"	1200MM	1143-1219MM	1.5-24MM	20KG
Model	Max. pipe size	Stroke	Clamp diameter	Wall thickness	Weight												
158C-25	60"	1200MM	1143-1219MM	1.5-24MM	20KG												
16	Отвертка		КОМ														
17	Төмрийн хөрөөний ир		Ш	5													
18	Bit box хошуу																
19	Газов №2, №3		Ш	2													

20	Зэс хоолой матагч			
	Хүйтэн гагнуурын багаж			
	Хоолой таслагч			
	Хоолойн ам цэвэрлэгч			
21	Харандаа			
22	Баллуур			
23	ХАБЭА хувцас			
24	M10 тогтоогч	МУЧ-2018 онд хийж байсантай адил хүрэлцэхүйц хэмжээгээр өөрсдөө хийж ирэх		
25	M8 тогтоогч			

Жич: Удирдамжид заагдаагүй багаж хэрэгсэл, цахилгаанаар ажилладаг ямар нэг төрлийн багаж тэмцээний талбайд ашиглахгүй

2. Сантехникийн материал болон туслах материал

Сантехникийн материал болон туслах материалыг уралдааны оролцогч бүрт зохион байгуулагч тал урьдчилан бэлдсэн байна.

Санамж:

- Үнэлгээнд оролцогч нь хөдөлмөр хамгааллын хувцас өмсөж, хувийн бэлтгэлээ хангасан байна.Үүнд:
 - Ажлын хувцас
 - Хөдөлмөр хамгааллын нүдний шил
 - Чихэвч эсвэл чихний бөглөө
 - Ажлын гутал
 - Хошуувч / зүлгэлтийн үед ашиглах /
 - Анхны тусламжийн хувийн хэрэгсэл / Жишээ нь: эмчийн хяналт дор байнга уудаг эм, үнэртүүлэгч, хурууны лент гэх мэт/
- Оролцогч нь ажлаа эхлэхийн өмнө тухайн материал нь шаардлагад нийцэж буй эсэхийг шалгасан байх ёстой.
- Угсрах тоноглол материалд ямар нэг өөрчлөлт орсон байж болохгүй бөгөөд зайлшгүй өөрчлөлт орсон тохиолдолд тэмцээний ерөнхий шүүгч тухайн материал дээр цаашид ажиллаж болох эсэх талаар шийдвэр гаргана.
- Үнэлгээнд өрсөлдөгч нар нь угсрах хоолой, материалыг тодорхой байрлалд, тодорхой хугацаанд угсарч бэлтгэнэ.
- Шугам хоолой, материалыг угсарч бэлтгэх үед түүнд ямар нэг гэмтэл учруулсан тохиолдолд түүнийг сольж өгөхгүй, харин оролцогч өөрөө засаж болно.
- Шүүгч нар материалаа шаардлагын хүрээнд угсарч бэлтгээгүй хүнд түүнийг засаж хийхийг шаардлага тавина.
- Үнэлгээнд тусгай дохиогоор эхлэнэ. Оролцогч 5 минут ба түүнээс дээш хугацаагаар хоцорсон тохиолдолд тэмцээнээс хасагдсанд тооцно.
- Үнэлгээний явагдах хугацаа – 6 цаг
- Үнэлгээний үед багаж хэрэгсэлтэй ажиллах ХАБЭА-г хангаж ажиллана.
- Шаардлагатай багаж хэрэгслийг тухайн МСҮТ хангана.
- Оролцогч дангаараа ажиллана.
-

Ес. Оролцогчийн ажилбарт өгөх үнэлгээ өгөх, байр эзлүүлж дүгнэх

Үнэлгээнд оролцогчдын гүйцэтгэсэн ажлын даалгаврыг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдээр БНБД, стандартын дагуу үнэлж, шалгах ажлыг журмын дагуу оноогоор дүгнэнэ. Үнэлгээнд оролцсон оролцогчдыг үнэлэхдээ ажилбар бүрийг дүгнэж нийт авсан онооны нийлбэрээр цуваагаар байр эзлүүлнэ.


1. Үнэлгээнд оролцогч ур чадварын 3 ажлын даалгаврыг нийт 8 цагийн хугацаанд гүйцэтгэнэ. /Даалгавруудыг хавсаргав./
2. Оролцогчид тэмцээний эхний хэсэг болох “Халаалтын системийн угсралт болон холболт хийх” ажлын даалгаврыг гүйцэтгэнэ.
3. Оролцогчид тэмцээний хоёр дахь хэсэг болох “Ариутгах татуургын системийн угсралт болон холболт хийх” ажлын даалгаврыг гүйцэтгэнэ.
4. Оролцогчид тэмцээний гурав дахь хэсэг болох “ Усан хангамжийн системийн угсралт болон холболт хийх” ажлын даалгаврыг гүйцэтгэнэ.
5. Удирдамжинд заасан багаж хэрэгслийг оролцогч үнэлгээнд оролцохоор ирэхдээ бэлдэж авчирна.
6. Үнэлгээ эхлэхээс өмнө үнэлгээчид багажны хайрцгуудыг шалгана. / Удирдамжинд зааснаас бусад багаж хэрэгслийг ашиглахгүй/
7. Үнэлгээнд оролцогчдын тоо, үнэлгээ явагдах орчин нөхцөлөөс хамаарч үнэлгээг 2 өдөрт явуулах бөгөөд тухайн өдөр бүр даалгавар нь өөр өөр өөрчлөлттэй, хэмжээтэй байна.

Арван: Үнэлгээнд оролцогчийн ажилбарт үнэлгээ өгөх, байр эзлүүлж дүгнэх



Үнэлгээний ажлын даалгаврын гүйцэтгэлийг үнэлэхдээ үнэлгээчид шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлгээ өгнө. Үнэлгээчин бүр шалгуур үзүүлэлтүүдийг дүгнэж нэгдсэн оноог тавина. Авсан онооны байдлаар цуваагаар байр эзлүүлнэ.

	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд	Оноо
A	ХХАА (Цахилгааны болон ХХХ)	2.00
B	Халаалтын систем угсралт суурилуулалт	37.00
C	Усан хангамжийн систем угсралт суурилуулалт	32.00
D	Ариутгах татуурын систем угсралт суурилуулалт	23.00
E	Угсралтын даралтаар шалгах	6.00
	Нийт	100.00 оноо

Ес: Ажлын даалгавар:q



Сантехникийн мэргэжлийн ур чадварын уралдаан 2021. 2-р шат



Сантехникийн мэргэжлийн ур чадварын уралдаан 2021. 2-р

